



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 538

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх, журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 224,430,750.00 (хоёр зуун хорин дөрвөн сая дөрвөн зуун гучин мянга долоон зуун тавин) төгрөгийн балансын үнэ, 130,115,365.12 (нэг зуун гучин сая нэг зуун арван таван мянга гурван зуун жаран таван төгрөг арван хоёр мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автомашиныг “Баруун бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын өрөнхий захирал Х.Бадамсүрэн, “Баруун бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Р.Нямтуул наарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0001311

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2019 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн  
Дугаар тогтоолын хавсралт

**"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРААС "БАРУУН БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ  
ХУВЬЦААТ КОМПАНИД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН**

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хурумтлагдсан элэгдэл (төгрөг)	Үндэх өртөг (төгрөг)
1	Лексус LX 570, 0405 УНТ /улсын дугаар сольсон 15-45 УНҮ/, арлын дугаар-ЛТДНУ0000WX94021828	2008/2008	224,430,750.00	130,115,365.12	94,315,384.88
	<b>Нийт</b>		<b>224,430,750.00</b>	<b>130,115,365.12</b>	<b>94,315,384.88</b>
	<b>Нийт дүн</b>		(хоёр зуун хорин дөрвөн сая дөрвөн зуун гучин мянга долоон зуун тавин төгрөг)	(нэг зуун гучин сая нэг зуун арван таван мянга гурван зуун жаран таван төгрөг арван хоёр мөнгө)	(өрэн дөрвөн сая гурван зуун арван таван мянга гурван зуун наян дөрвөн төгрөг наян найман мөнгө)